



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/31

Баян-Өндөр сум

┌ Арга хэмжээ зохион байгуулж, хөрөнгө ┐
гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2026 оны А/348 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх тухай” зарлигийн хүрээнд Орхон аймагт уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх 2026 оны арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан удирдамжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн чанар эрсдэл, магадлан итгэмжлэл, яаралтай тусламж үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Хишгээ), Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн уламжлалт анагаах ухаан сэргээн засах тусламж үйлчилгээ, хөгжилийн бэрхшээлтэй иргэдийн асуулал хариуцсан мэргэжилтэн (Т.Нарантуяа) нарт үүрэг болгосугай.

3. Шаардлагатай 6.000.000 (Зургаан сая) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодох ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн (М.Бямбасүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
04 дүгээр сарын 26 өдрийн 131
тушаалын нэгдүгээр хавсралт
9043446 2020030036

ОРХОН АЙМАГТ УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ

2026 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн тогтолцоо бүрдсэний 345 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 87 дугаар тогтоолоор уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх, тусламж үйлчилгээнд орчин үеийн анагаах ухаантай уялдуулан хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

Дээрх бодлогын хүрээнд уламжлалт анагаах ухааны салбарын үр нөлөөг нэмэгдүүлэх, эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, чадавхжуулах тусламж үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

Дэлхийн хэмжээнд халдварт бус өвчин нь нас баралтын тэргүүлэх шалтгаан болж, нийт нас баралтын 74 хувийг эзэлж байгаа бөгөөд зохисгүй хооллолт, архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол зэрэг эрсдэлт хүчин зүйлс зонхилж байна. Эдгээр хүчин зүйлс нь илүүдэл жин, таргалалт, артерийн даралт ихсэлт, цусан дахь өөх тос болон сахарын солилцооны алдагдлыг үүсгэж, улмаар өвчлөл, нас баралтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчлөлийн тархалт, эрсдэлт хүчин зүйлс нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Иймд Орхон аймгийн хүн амын дунд уламжлалт анагаах ухаанд суурилсан эрүүл амьдралын хэв маяг, зохистой хооллолт, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг төлөвшүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, мөн салбарын эмч, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна

Хоёр. Зорилго

Монголын уламжлалт анагаах ухаанд суурилсан эрүүл амьдралын хэв маяг, зохистой хооллолт, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг Орхон аймгийн хүн амын дунд төлөвшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, мөн уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хүн амын өвчлөл, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад оршино

Гурав. Зорилтууд:

1. Уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх
2. Иргэдэд эрүүл амьдралын хэвшлийн талаарх мэдлэг олгох, дадал хэвшүүлэх
3. УАУ-д суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөжүүлэх
4. Байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх
5. Олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх

Дөрөв. Хамрах хүрээ: Орхон аймгийн 29 багийн иргэд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд

Тав. Хэрэгжих хугацаа 2026 оны 01 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл үе шаттай хэрэгжүүлнэ.

Зургаа. Хамтран ажиллах байгууллага:

- Аймгийн Засаг даргын Тамгын газар
- Эрүүл мэндийн газар
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- Хойд бүсийн хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв
- Сум өрхийн эрүүл мэндийн төвүүд
- Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн эмнэлгүүд

Долоо. Хүлээгдэх үр дүн:

1. Уламжлалт анагаах ухааны үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ
2. Уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтнүүдийн ур чадвар, мэргэжлийн боловсон хүчний чадавх сайжирна.
3. Иргэдийн эрүүл амьдралын хэвшил, эрүүл мэндийн боловсрол дээшилнэ сайжирна
4. Урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал нэмэгдсэн байна
5. Өвчлөл буурах нөхцөл бүрдэнэ
6. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний хэрэглээ, хандалт нэмэгдэнэ.

Найм. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Шалгуур үзүүлэлт
1	Уламжлалт анагаах ухаанд суурилсан эрүүл амьдралын хэв маяг, зохистой хооллолтын талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах	2026.03-2026.12	ЭМГ	Эрүүл мэндийн байгууллагууд	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо, хамрагдалтын хувь
2	Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, зөвлөгөө зохион байгуулах	Жилд 2 удаа		ЭМБ-ууд	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо, илрүүлсэн тохиолдол
3	Уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтнүүдийн сургалт, семинар зохион байгуулах	II, IV улиралд		УАУ-ны нөлөөллийн баг	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо
4	Эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, нөлөөллийн ажлыг хэвлэл мэдээлэл, цахим орчинд зохион байгуулах	Сар бүр		Орхон аймгийн Уламжлалт анагаах ухааны их эмч нар	Хандалт, хүртээмж, мэдээллийн тоо
5	Иргэдэд зориулсан гарын авлага, зөвлөмж, сургалтын материал боловсруулах, түгээх	Сар бүр		ЭМБ-ууд, УАУ-ны нөлөөллийн баг	Боловсруулсан материалын тоо, түгээлтийн хувь
6	Уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны уялдаа холбоог сайжруулах хамтын ажиллагааг бэхжүүлэх	Жилд 2 удаа		ЭМБ-д	Хамтарсан үйл ажиллагааны тоо
7	Мэргэжлийн чадварын АХА болон	Жилд 1 удаа		ЭМБ	Оролцсон хүний тоо

	хөгжөөнт тэмцээн				
8	Судалгаа шинжилгээний ажлыг хийх	Жилд 1 удаа		Нөлөөллийн баг	Хийгдсэн судалгааны тоо
9	Хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах	Жилд 2 удаа		ЭМБ-ууд	Тайлангийн биелэлт, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
 ...04 дүгээр сарын 16 өдрийн 431
 Тушаалын хоёрдугаар хавсралт



Шаардагдах төсөв

Д/д	Үйл ажиллагаа	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн /төгрөг/
1	Сургалт сурталчилгаа	Сургалт зохион байгуулалт, сургалтын материал хэвлэл, бичиг цаас	6 удаа	100.000	600.000
2	Үзлэг, оношилгоо	Хэрэглэгдэх зүйлс	2 удаа	500.000	1.000.000
3	Эмч мэргэжилтний сургалт	Сургалтын материал	2 удаа	500.000	1.000.000
4	Мэдээлэл нөлөөлөл, гарын авлага	Медиа контент бэлтгэл	Сард 1 удаа 8 сар хийх	50.000	400.000
5	Хамтын ажиллагаа	Уулзалт, зөвлөгөөн	1 удаа	2.000.000	2.000.000
6	Судалгаа	Судалгаа хийхэд хэрэгдэгдэх бичиг цаас	1 удаа	500.000	500.000
7	Мэргэжлийн чадварын АХА болон хөгжөөнт тэмцээн	Хэрэглэгдэх зүйлс, заал танхимын зардал	1 удаа	500.000	500.000
8	Нийт дүн				6.000.000